

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны саналын дагуу хийсэн эрсдэлийн аудитын тайлан

Кувейтын сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Булган-Уньт” чиглэлийн авто зам барих ажлын хэрэгжилт



Гэрээг хоёр удаа сунгасан ч хэнч хариуцлага хүлээгээгүй байна

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....2
Үндэсний аудитын газар	
Газрын захирал Д.Ганбилэг	Бүлэг 1
Аудитын менежер Х.Баярмаа	<ul style="list-style-type: none">• Оршил.....3• 3А хэсгийг 2009 онд ашиглалтад оруулж, улсын комисст хүлээлгэн өгчээ.....4• 3В хэсгийг 2009 онд ашиглалтад оруулж, 3С хэсэг 52.08 хувийн гүйцэтгэлтэй байна.....4• Гэрээний хариуцлага тооцоогүй байна.....7• Үнийн өсөлтөөс шалтгаалан ажил дуусахад бэрхшээл гарчээ.....8
2010 оны 6 дугаар сар	
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	
www.mnao.mn	Дүгнэлт.....10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263755, 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу	Зөвлөмж11
ХАЯГ:	Хавсралт 1. Насны зам ХХК-иас аудитын явцад ирүүлсэн тайлбар.....12
Үндэсний аудитын газар Засгийн газрын IV байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 15160 Монгол Улс	

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны саналыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Кувейтын сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Булган-Уньт” чиглэлийн авто зам тавих ажлын хэрэгжилтэд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Санхүүжилт хугацаандаа бүрэн олгогдсон эсэх;
- Ажил гэрээнд заасан хугацаандаа хэрэгжиж байгаа эсэх;
- Гэрээний хариуцлага хэрхэн тооцсон

Хамарсан хүрээ

Кувейтын сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Булган-Уньт” чиглэлийн авто зам барих ажлын төслийн нэгж, Авто замын газар, гүйцэтгэгч компаниудын 2007-2009 оны үйл ажиллагааг ажил гүйцэтгэх гэрээ, ажлын тайлан, зарим судалгаа, мэдээлэл, холбогдох бусад материалд тулгуурлан шалгав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглав.

Аудитын тайланд төлөвлөлтийн шатанд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, илрүүлсэн зүйлс, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, судалгаанаас гадна холбогдох байгууллагын саналыг тусгав.


Бүлэг 1

Оршил

“Үдэгийг-Аоёааг-Ойуудыг аагч цаг дор”-еэ (MON-655) дүрэмчилж үйлдвэрлэж, Иргэдийн Удирдлага, Агаарын тээврийн үйлчилгээний Ерөнхий газартай 2003 оны 1 сарын 7-ийн өдөр зүүдний гэрээг байгуулж, 2003 оны 1 сарын 10-ийн Иргэдийн Удирдлагад нийцүүлэн агааржуулав. Үйлдвэрчилж үйлдвэрлэж, Ерөнхий газартай нийцүүлэн 17 хувийн оролцоотой үйлдвэр дор 6 сарын өдөр агааржуулав 19,5 сарын агааржуулах үйлдвэр Иргэдийн Удирдлагад өөрийн агааржуулах үйлдвэр дор 2,5% хувиар. Үйлдвэрлэж агааржуулах үйлдвэр 80 хувийг Ерөнхий газартай, 20 хувийг Иргэдийн Удирдлагад өөрийн агааржуулах үйлдвэр агааржуулав.

Өөрийн үйлдвэр 6 сарын өдөр үйлдвэрлэж, 9 сарын өдөр агааржуулав, 3 сарын үйлдвэр агааржуулав 146 өдөр үйлдвэрлэж цаг агааржуулав байна. Үйлдвэр:

1. Үдэгийг доторхи 3.7 өдөр цаг
2. Үдэгийг-Аоёааг 53.8 өдөр цаг
3. Аоёааг-Ойуудыг 88.5 өдөр цаг



Агааржуулах үйлдвэрүүд Ерөнхий газартай Combined Group Co., For Trading and Contracting W.L.L өөрийн үйлдвэрлэж, агааржуулах үйлдвэрүүдийг бөгөөд 1 сарын үйлдвэрлэж цаг 2005 оны 2 сарын үйлдвэрлэж цаг 2007 оны агааржуулах үйлдвэрлэж цагтай байна. Гүйцэтгэгч үнийн өсөлт гарсантай холбогдуулан гэрээний үнийн дүнг нэмэгдүүлэх, заагчдын үйлдвэрлэж цагтай холбогдуулан өөрийн үйлдвэрлэж цагтай шаардлага тавьсан бөгөөд захиалагч гэрээний үндэрт өөрчлөлт хийхгүй байхаар шийдвэрлэж, гэрээ цуцлагджээ.

3 дугаар хэсэг буюу Булган-Уньтын замд дахин тендер зарлаж, цаг агааржуулах үйлдвэрүүд агааржуулах үйлдвэрлэж цагтай Иргэдийн Удирдлагад өөрийн агааржуулах үйлдвэрлэж цагтай дараахь компаниуд шалгарчээ. Үүнд:


- 3А үйлдвэр буюу Аоёааг-Агааржуулах үйлдвэр 14.5 өдөр цаг Эрдэнэ зам ХХК
- 3Б үйлдвэр буюу Агааржуулах үйлдвэр-хатгалгачдын үйлдвэр 14 өдөр цаг Насны зам ХХК
- 3В үйлдвэр буюу хатгалгачдын үйлдвэр-Ойуудыг үйлдвэрлэж цагтай 60 өдөр цаг Насны зам ХХК

3А хэсгийг дотоодын сонгон шалгаруулалтаар улсын төсвөөс санхүүжүүлэхээр, 3В, 3С хэсгийг олон улсын сонгон шалгаруулалтаар Кувейтын сангаас санхүүжүүлэх болжээ.

Замын ажилд Кувейтын хөрөнгө оруулалттай Энэтхэгийн Аи Си Ти компани хяналт тавьж, зөвлөх компаниар ажиллаж байна. Гэрээгээр замын ажлыг жил бүрийн 5 дугаар сараас эхлүүлж, 10 дугаар сарын 31-д дуусгахаар заажээ.

3А хэсгийг 2009 онд ашиглалтад оруулж, улсын комисст хүлээлгэн өгчээ


3А хэсгийн тендерийг 2007 оны 12 дугаар сарын 12-нд зарласан бөгөөд гүйцэтгэгчээр “Эрдэнэ зам” ТӨХК шалгарсан. Ажил гүйцэтгэх гэрээг 2008 оны 4 дүгээр сарын 25-д байгуулж, ажлыг 5 дугаар сарын 5-ны дотор эхлүүлсэн байна. Зам барих ажлын гүйцэтгэлийг жил жилээр харуулбал дараахь байдалтай байна.



Зураг 1. 2008 оны 10 дугаар сарын 31-ний байдлаарх гүйцэтгэл
Эх сурвалж: Зөвлөх компаний 2008 оны 10 дугаар сарын ажлын тайлан

2008 онд ажлыг дуусгахаар төлөвлөсөн бөгөөд ажлын гүйцэтгэл 43.03 хувь байна гэж зөвлөх компани дүгнэжээ.

Зураг 2. 2009 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар



Эх сурвалж: Зөвлөх компаний 2009 оны 10 дугаар сарын ажлын тайлан


2009 онд замыг үндсэнд нь дуусгаж улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Зөвлөх компаний 10 дугаар сарын тайлангаар нийт ажлын 92.96 хувь хийгдсэн бөгөөд гүйцэтгэгч 2010 оны 5 дугаар сард бүрэн дуусгана гэсэн байна. Барилга угсралтын бус ажил үлджээ.

3В хэсгийг 2009 онд ашиглалтад оруулж, 3С хэсэг 52.08 хувийн гүйцэтгэлтэй байна

3В, 3С хэсгийн Олон улсын тендерийг 2006 оны 11 дүгээр сард зарласан бөгөөд “Iañiú Çàì” ÕÕË ã¿éöýðäýã÷ýýð øàëããàð÷, 2007 ïú 4 ä¿äýýð ñàðüí 18-íú òãð Çàì, öýýäýð, äýëàë

æóöë-ëäëüí ÿàìòàé åýðúú áàéåóóëжээ. 3В хэсгийн ажлын гүйцэтгэлийг жил жилээр харуулбал дараахь байдалтай байна.


Зураг 3. 2007 оны 10 дугаар сарын 31-ээрх гүйцэтгэл



Эх сурвалж: Зөвлөх компаний 2007 оны 10 дугаар сарын ажлын тайлан

Зөвлөх компаний 2007 оны 10 дугаар сарын ажлын тайлангаар 3В хэсгийн ажлын гүйцэтгэл 14.8 хувьтай байжээ.


Зураг 4. 2008 оны 10 дугаар сарын 31-ээрх гүйцэтгэл



Эх сурвалж: Зөвлөх компаний 2008 оны 10 дугаар сарын ажлын тайлан

2008 онд ажлыг дуусгахаар төлөвлөсөн боловч ажлын гүйцэтгэл 70.19 хувьтай байна гэж зөвлөх компани үнэлсэн байна.

Зураг 5. 2009 оны 10 дугаар сарын 31-ээрх гүйцэтгэл



Эх сурвалж: Зөвлөх компаний 2009 оны 10 дугаар сарын ажлын тайлан

2009 онд 3В хэсгийн замыг үндсэнд нь дуусгаж улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Зөвлөх компани нийт ажлын 96.62 хувь хийгдсэн бөгөөд гүйцэтгэгч 2010 оны 5, 6 дугаар сард дуусгана гэсэн байна.

3С хэсгийн ажлын гүйцэтгэлийг жил жилээр харуулбал дараахь явцтай байжээ.

Зураг 6. 2007 оны 10 дугаар сарын 31-ээрх гүйцэтгэл

SECTION-3C (Chachirt River- Unt Road) 60km.

Item of Works	Chachirt River- Unt Road						Completed Length (km)
Asphalt concrete							
Base course							
Granular subbase							
Non-frost subgrade							
Exc/Embankments							
Site clearance							

28+700 36+700 46+700 58+700 68+700 78+700 88+700

Эх сурвалж: Зөвлөх компаний 2007 оны 10 дугаар сарын ажлын тайлан

Зөвлөх компаний ажлын тайлангаар 2007 онд 3С хэсэгт ажил хийгдээгүй, гүйцэтгэл 0.00 хувь гэж үнэлсэн байна.

Зураг 7. 2008 оны 10 дугаар сарын 31-ээрх гүйцэтгэл

SECTION-3C (Chachirt River- Unt Road) 60km.

Item of Works	Chachirt River- Unt Road											Completed Length (km)
Asphalt concrete												
Base course												
Granular subbase												
Non-frost subgrade												7.6km
Exc/Embankments												28.1km
Site clearance												60.0km

28+700 30+000 35+000 40+000 45+000 50+000 55+000 60+000 65+000 70+000 75+000 80+000 88+700

Эх сурвалж: Зөвлөх компаний 2008 оны 10 дугаар сарын ажлын тайлан

Зөвлөх компани ажлын гүйцэтгэлийг 20.78 хувьтай гэж дүгнэсэн байна.

Зураг 8. 2009 оны 10 дугаар сарын 31-ээрх гүйцэтгэл

Section - 3C ; Chachirt River- Unt Road (60.00km)

Item of Works	Completed Length (km)		In progress (km)
Asphalt concrete	3.6km		
Base course	6.7km	8.0km	
Granular subbase	46.1km	13.9km	
Non-frost subgrade	58.0km	2.0km	
Exc/Embankments	58.0km	2.0km	
Site clearance	60.0km		

1+700 1+000 1+000 2+000 3+000 3+000 3+000 3+000 3+000 3+000 3+000 3+000 3+700

2009 онд 100 хувь гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд 52.08 хувийн гүйцэтгэлтэй байна. Ажлыг 2010 оны 9 дүгээр сарын 30-д дуусгахаар гэрээгээ сунгажээ. Зөвлөх компани энэ хэсгийн ажил дуусаагүйг гүйцэтгэгч компани шаардлагатай хүний нөөцийг байршуулаагүйтэй холбоотой гэж үзсэн байна.

Төслийн удирдах нэгжээс өдөр тутмын ажлын гүйцэтгэлийн мэдээг гаргуулан хянадаг бөгөөд ажлын талбарт ажилласан хүний тоог сар, жилээр үзүүлбэл дараахь байдалтай байжээ.

Хүснэгт 1. 3А хэсэгт ажилласан хүний тоо

Сар	5	6	7	8	9	10
2008 онд ажилласан хүний тоо	17-34	35-68	49-55	56-68	59-62	58-68
2009 онд ажилласан хүний тоо	98-100	95-98	30-96	10-27	15-64	61

Хүснэгт 2. 3В хэсэгт ажилласан хүний тоо

Сар	5	6	7	8	9	10
2007 онд ажилласан хүний тоо		24-40	24-40	36-45	38-64	25-73
2008 онд ажилласан хүний тоо	82-183	130-183	61-106	31-85	84-85	69-90
2009 онд ажилласан хүний тоо	0	11	15-35	57-67	41-57	26-41

Хүснэгт 3. 3С хэсэгт ажилласан хүний тоо

Сар	5	6	7	8	9	10
2007 онд ажилласан хүний тоо	0	0	0	0	0	0
2008 онд ажилласан хүний тоо	18	18-199	199	192-242	242	242
2009 онд ажилласан хүний тоо	107	126-133	138-174	174-222	222	222

2007 онд 3С хэсэгт хүн ажиллаагүй, 3В хэсэгт 24-73 хүн ажилласан үүний улмаас ажлын гүйцэтгэл хангалтгүй байсан байна.

Гэрээний хариуцлага тооцоогүй байна

3А хэсгийн ажил гүйцэтгэх гэрээг 2008 оны 4 дүгээр сарын 25-д байгуулж, тухайн ондоо хэрэгжүүлж дуусгахаар байжээ. 3В, 3С хэсгийн ажлыг гүйцэтгэх гэрээг 2007 оны 4 дүгээр сарын 18-д ЗТАЖЯ-тай байгуулж, 3В хэсгийг 2008 оны 7 дугаар сарын 30-нд, 3С хэсгийг 2008 оны 10 дугаар сарын 31-д ашиглалтад оруулахаар тус тус заажээ. Гэвч цаг агаарын саатал их гарсан, ажиллах хүчний зөвшөөрөл хугацаандаа гараагүй, барилгын материал, шатахууны үнэ өссөн, санхүүжилт хугацаандаа хийгдэхгүй байгаа зэрэг шалтгааны улмаас гүйцэтгэгчдийн зүгээс гэрээг сунгах хүсэлт гаргасны дагуу Төслийн удирдах хороо 2009 оны 4 дүгээр сарын 1, 2010 оны 1 дүгээр сарын 7-нд хуралдаж гэрээний хугацааг 2 удаа сунгажээ. 3С хэсгийн гэрээний хугацааг 2010 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр дуусгавар болгохоор сунгасан байна.

Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сан, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан гэрээний 4.17 дугаар хэсэгт “Энэхүү гэрээ нь Зээлдэгчийн нутаг дэвсгэр дээр одоо хэрэгжүүлэн мөрдөж байгаа болон цаашид мөрдөгдөх хууль дүрмийн хүрээнд хэрэгжүүлэх, бүртгүүлэх болон түүнтэй холбоотой төлөгдвөл зохих ямар ч төрлийн аливаа татвар, хураамжаас чөлөөлөгдөх бөгөөд зээлдэгч нь валютаар зээлийн төлбөрийг хийх бусад орны (Кувейт улсаас бусад) хуулийн хүрээнд төлөгдвөл зохих бүх татвар хураамжийг төлөх буюу төлөх боломжийг хангана.” гэж заасны дагуу олон улсын тендерээр 3В, 3С хэсэгт шалгарсан Насны зам ХХК БНХАУ-аас ажиллах хүчин оруулж ирэх, гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулсны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдөхөөр болжээ.

Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоол оройтож гардгаас гүйцэтгэгч компанид бэрхшээл учирдаг байна.

Ажиллах хүчин авах жил	Гүйцэтгэгч компани хүссэн огноо	Засгийн газрын тогтоол гарсан огноо
2007 онд ажиллах	2007 оны 5 дугаар сарын 15	2007 оны 8 дугаар сарын 30
2008 онд ажиллах	2007 онд 12 дүгээр сарын 18	2008 онд 2 дугаар сарын 27
	2008 оны 3 дугаар сарын 19	2008 оны 4 дүгээр сарын 9
2009 онд ажиллах	2008 оны 12 дугаар сарын 15	2009 онд 4 дүгээр сарын 8
2010 онд ажиллах	2009 оны 11 дүгээр сарын 16	2010 онд 4 дүгээр сарын 21

Насны зам ХХК 2007 онд тогтоол оройтож гарсан шалтгаанаар БНХАУ-аас ажиллах хүчин оруулж ирээгүй, 2008 онд 328, 2009 онд 229 хүн авчээ. Ажил жил бүрийн 5 дугаар сараас эхлэх ёстой боловч тогтоол гарснаас хойш гадаадаас ажиллах хүч оруулж ирэхэд наад зах нь 14-21 хоног шаардагддаг ба шийдвэр оройтож гарах нь ажил удаашрах шалтгаан болдог байна.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4¹-т заасны дагуу Засгийн газар жил бүр гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоодог бөгөөд авто замын салбарт 2007 оны 58 дугаар тогтоолоор 32 хувь, 2008 оны 75 дугаар тогтоолоор 45 хувь, 2009 оны 59 дүгээр тогтоолоор 40 хувь байхаар тус тус заажээ. Мөн ажил гүйцэтгэх гэрээний 16.4-т “нийт ажиллах хүчний 60-аас багагүй хувь нь Монгол улсын иргэд байна” гэж заасан.

Дээрх заалтаар Насны зам ХХК-д 2007 онд 388, 2008 онд 400, 2009 онд 343 үндэсний ажиллах хүч, мэргэжилтэн ажилласан байхаар байна. Гэтэл 2007 онд 24-73 дотоодын ажилтан, 2008, 2009 онд авсан гадаад ажиллах хүчний тоотой харьцуулбал үндэсний мэргэжилтэн бараг ажиллаагүй гэж үзэхээр байна. Түүнчлэн тус компани 2007 онд Өндөрхаан-Сүмбэр чиглэлд 2007-2008 онд 50 км автозам барих ажил давхар гүйцэтгэж хүч нь тарамдаж байсан байна.

Эрдэнэзам ХК ЗА хэсгийн 14.5 км замыг дотоодын ажиллах хүчнээр ажлын 12 сар буюу 2 жилийн хугацаанд ашиглалтад өгсөн бол Насны зам ХХК 14 км замыг ажлын 18 сар буюу 3 жилийн хугацаанд ашиглалтад өгчээ. Нарийвчилсан ажлын зөрүү бий боловч замын урт, ажлын ерөнхий байдал ижил төстэй байна.

ЗВ, ЗС хэсгийн гэрээнд гүйцэтгэгч ажиллаагүй нэг хоногт 3300 ам.доллар төлөхөөр заагдсан боловч Төслийн удирдах зөвлөл гэрээний 44.1²-ийн с, d, e-д заалтуудыг үндэслэн гэрээний хугацааг сунгасан тул алданги тооцоогүй байна.

Үнийн өсөлтөөс шалтгаалан ажил дуусахад бэрхшээл гарчээ

ЗА хэсэгт 3.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд 2010 оны 5 дугаар сарын 18-ны байдлаар 2.7 тэрбум төгрөгийг санхүүжүүлж 281.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнгийн үлдэгдэлтэй байна.

ЗВ хэсэгт Кувейтын сангаас 2.0 сая, МУ-ын Засгийн газраас 459.1 мянга, нийт 2.5 сая ам.долларын санхүүжилт авсан байна. ЗС хэсэгт Кувейтын сангаас 7.2 сая, МУ-ын Засгийн газраас 1.4 сая, нийт 11.4 сая ам.долларын санхүүжилт авсан байна. Төслийн санхүүжилтийг гүйцэтгэгчээс зөвлөх компани, төслийн удирдах нэгж, ЗТАЖЯ, Сангийн яам, Кувейтын сан хянан баталгаажуулалт хийж байна. ЗС, ЗВ хэсгийн захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ажлын гэрээний 60.8-д гүйцэтгэгч нь сар бүрийн ажлын гүйцэтгэлийг зөвлөх компанид хүлээлгэн өгснөөс хойш 42 хоногийн дотор завсрын төлбөрийг санхүүжүүлэхээр заасан боловч ЗВ хэсэгт 230 хоног, ЗС хэсэгт 171 хоног саатсан байна.

2009 онд ЗА хэсгийн гүйцэтгэгч Эрдэнэ зам компани 2007 онд тендерт оролцох үед тооцож гаргасан төсөвт өртгөөс 1.0 тэрбум орчим төгрөг нэмэгдэж гарсан тул тус асуудлыг шийдвэрлэх хүсэлт төслийн удирдлага болон зөвлөх компанид гаргажээ. 2009 оны 8 дугаар сард захиалагч, гүйцэтгэгч нэмэлт гэрээ байгуулж 354.8 сая орчим төгрөгийн асуудлыг шийдвэрлэж, 173.6 сая төгрөгийг улсын төсвөөс олгон,

¹ 4.1.4. “эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын нийт ажиллагчдын тоо, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан нийт ажиллагчдын тоонд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг жил бүр тогтоож, Засгийн газраар батлуулах;”

² 44.1 Дуусгах хугацааг сунгах

с- Цаг агаарын тааламжгүй нөхцөл байдал

d- Ажил олгогчийн саатал

e- Гэрээлэгчийн үүрэг хариуцлагаас бус бусад нөхцөл байдал

үлдэх хэсгийг компани өөрийн эрсдэлээр хүлээн зөвшөөрчээ. Одоо 715.0 сая төгрөгийн нэхэмжлэлийн асуудал шийдвэрлэгдээгүй байна.

ЗВ, ЗС хэсгийн гүйцэтгэгч Насны зам ХХК 6.0 сая ам.долларын нэмэлт санхүүжилт шаардлагатай байгаа тухай хүсэлтийг гэрээний 70.1-д заасны дагуу гаргасан бөгөөд Төслийн удирдах нэгж болон зөвлөх компани хянаж үзээд 4.4-4.1 сая ам.доллар байхаар тооцжээ.

Насны зам ХХК Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн 50 км зам тавьсан бөгөөд 2008 оны үнийн өсөлт гарсантай холбогдуулан 2009 оны 8 дугаар сард 378.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

Ажил хугацаандаа дуусаагүй нь дараахь шалтгаантай байна. Үүнд:

- Гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулсны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх зөвшөөрлийг Засгийн газар оройтуулдгаас зам барилгын ажил хугацаандаа эхэлдэггүй байна.
- Компаний бодит хүчин чадлыг харгалзахгүйгээр олон газрын объект дээр ажиллуулахаар тендерт шалгаруулсан байна.
- Захиалагчаас гүйцэтгэгчид шилжүүлдэг завсрын санхүүжилт саатдаг байна.
- Гүйцэтгэгч компани дотоодын ажиллах хүчийг бүрэн ажиллуулаагүй байна. Тухайлбал, 2007 онд ЗС хэсэгт ажил хийгдээгүй, ЗВ хэсэгт 24-73 хүн ажилласны улмаас ажлын гүйцэтгэл хангалтгүй болжээ.
- Гүйцэтгэгч компаниуд цаг агаарын саатал, ажиллах хүчний зөвшөөрөл хугацаандаа гараагүй, барилгын материал, шатахууны үнэ өссөн, санхүүжилт хугацаандаа хийгдэхгүй байгаа зэрэг шалтгааны улмаас гэрээг сунгах хүсэлт гаргасны дагуу Төслийн удирдах хороо ЗА, ЗВ, ЗС хэсгийн ажил гүйцэтгэх гэрээний хугацааг 2 удаа сунгасан байна. Гэрээг сунгахдаа захиалагч, гүйцэтгэгчийн талаас хэн ч гэрээний үүргийн биелэлтийн хариуцлага хүлээгээгүй байна.
- 2010 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар ЗА, ЗВ хэсгийг улсын комисс хүлээн авсан, ЗС хэсгийн ажлын гүйцэтгэл 52.08 хувьтай байна. ЗС хэсгийн гэрээний хугацаа 2010 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр дуусгавар болохоор байна.
- 2007-2010 онд барилгын материал, шатахууны үнэ өссөнөөс анх тендерт оролцох үеийн төсөвт өртөг нэмэгдэж, ЗА хэсгийн гүйцэтгэгч компани Эрдэнэ зам ХК 715.0 сая төгрөг, Насны зам ХХК 6.0 сая ам. доллар нэхэмжилсэн байна. Насны зам ХХК-ний нэхэмжилсэн санхүүжилтийг Төслийн удирдах нэгж болон зөвлөх компани 4.4-4.1 сая ам.доллараар хянасан байна.

Зөвлөмж

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараахь зөвлөмжийг өгч байна.

Эрдэнэт-Булган-Уньтын чиглэлийн автозам барих төслийн Удирдах хорооны дарга, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын дэд сайд Т.Пүрэвдорж, Төслийн удирдах зөвлөлийн гишүүн, Сангийн яамны Зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Хүрэнбаатар нарт:

- Булган-Уньтын чиглэлийн автозамын захиалагч болон гүйцэтгэгчийн байгуулсан анхны гэрээ хугацаандаа хэрэгжээгүйн буруутай эзэн, шалтгааныг тогтоож түүний улмаас үүссэн нэмэлт өртөг зардлыг тооцож, гэрээнд заасны дагуу холбогдох этгээдэд хариуцлага тооцох
- Гүйцэтгэгчийн зүгээс нэмж шаардаж байгаа хөрөнгийн асуудлыг судлан үзэж, гэрээний заалт, хууль эрх зүйн үндэслэл зэргийг харгалзан зохих журмын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авах.

Автозамын газрын дарга Б.Энхтөр, Төслийн удирдагч Н.Адилбиш нарт:

- ЗС хэсгийн замыг гэрээний хугацаанд ашиглалтад оруулах, гарч буй бэрхшээлийг шийдвэрлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, биелэлтэд хяналт тавьж ажиллах.

Насны зам ХХК-иас аудитын явцад ирүүлсэн тайлбар



NASNII ZAM LLC

4-r khoroo, Suhbaatar district,
Ulaanbaatar, MONGOLIA,
Tel: 976-11-70110269,
Fax: 976-11-70110209,
E-mail: nasniizam@magicnet.mn

Date 26, May, 2010

Ref Bu/010/01

Булган Уньт төслийн 74км зам

барилгын ажлын талаар

Булган Уньт төслийн 74км зам нь Кувейтын сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжих төсөл бөгөөд манай компани 2007 онд гэрээ байгуулан одоогийн байдлаар барилгын ажлын гэрээг 2 удаа сунгуулж ажиллаж байна. Барилгын ажлын ашиглалтанд оруулах хугацаа төсөл хойшлогдоод байгаа дараах гол шалтгаанууд байна. Үүнд:

1. 2006 оны 11-р сард тендерт орж, 2007 оны 4-р сарын 25-ийн өдрийн гэрээ хийсэн. Уг төсөл дээр манай компани гадаадын ажиллах хүч, гадаадаас шинээр техник тоног төхөөрөмжийн хамт оруулж ажил гүйцэтгэх төлөвлөгөөтэй байсан. Гэрээ байгуулснаас эхлэн Гадаадаас ажиллах хүчин оруулж ирэх талаар холбогдох байгууллагуудад хүсэлт гаргасан боловч энэ тухай Монгол улсын Засгийн газрын тогтоол 2007 оны 08 сарын 30-ны өдөр гарсан болно. Тогтоол нь зөвхөн тэр жилдээ л хүчинтэй байдаг бөгөөд тогтоол гарсан өдрөөс хойш гадаадаас ажиллах хүчин оруулж ирнэ гэхэд дахин 1 сарын хугацаа шаардлагатай байсан тул 2007 онд гадаадаас ажиллах хүчин оруулж ирж чадаагүй юм. тухайн жил шинээр оруулж ирэх техник тоног төхөөрөмж хүн, хүч орж ирээгүйгээс бүрэн хүчин чадлаар ажиллаагүй. Зөвшөөрөл гарах үед барилгын ажлын улирал дуусаж байсан. 2007 онд ердөө л зам барилгыг ажил 10км далангийн ажил хийснээр дууссан.
2. 2008 онд хавараас техник тоног төхөөрөмжийг татаж эхлэсэн ба Замын-Үүд дахь төмөр замын тээврийн ачаалал ихтэй байсны улмаас зам барилгын ажилд хэрэглэгдэх техник, тоног төхөөрөмжүүдийг БНХАУ-аас оруулж ирэх ажил гацаанд орж, 2008 онд өөрийн болон түрээсийн ачааны том даацын авто машинаар Замын-Үүдээс Улаанбаатар-Булган хүртэл тээвэрлэлт хийсэн. Барилгын ажлын бетон хоолой гүүрийн цемент арматур, зэргийг дотоодын зах зээлээс олдохгүйн улмаас БНХАУ-с талбай хүртэл газраар тээвэрлэж байв. Нийт 3300тн цемент, 800тн арматур тээвэрлэсэн. Тухайн жилд гадаадын ажиллах хүч мөн хугацаа алдаж талбайд ирсэн.

Булган аймгийн нутаг нь уулархаг Хангайн бүс учраас хур тунадас их ордог ба 2007 оны 07 сараас 10-р сар хүртэл нийтдээ 57 хоног бороотой, 2008 оны 04 сараас 07-р сар хүртэлх хугацаанд 60 хоног бороотой байсан байна. Энэ байдал нь зам барилгын ажилд муугаар нөлөөлж, бороо орсон өдрөөс хойш 1-ээс доошгүй хоногоор газар хаттал ажил хийх боломжгүй байдаг нь цаг хугацаа алдахад нөлөөлж байна.


Үүнээс гадна замын ажлын үндсэн гол түүхийн эдийн болон шатахуун, ажиллах хүчний зардал нэмэгдсэн. Үүнээс үүдээд барилгын ажлын өртөг ихсэн ажил гүйцэтгэх боломжгүй болж эхлэсэн. 2008 оны 9-р сард үнийн зөрүүг тооцож олгох тухай хүсэлтээ гаргасан. Уг асуудал Зөвлөх компаниар шалгагдан захиалагчид очсон болно. **Гэрээний тусгай нөхцөлийн 70.1 заасан заалтын дагууд бид гэрээгээс заасан эрхээр үнийн зөрүүнийг тооцох авах ёстой. Гэрээний заалтыг хавсралтанд хүргүүлэв.**

3. 2009 онд үнийн өсөлтийг удаа дараа зохих шатны байгууллагуудад хандаж, 2009 оны 4-р сарын 1 өдрийн Төслийн удирдах хорооны хурлаар орж үнийн зөрүүний 2 сая ам.долларыг олгохоор шийдэгдсэн. Тус хуралдааны шийдэрт заасан ажлыг цаашид үргэлжлүүлэхэд хүндрэлтэй байгааг харгалзан барилгын ажлын өртгөөс урьдчилгаа өгөх нь зүйтэй гэж шийдэгдсэн. Уг урьдчилгаа нь 8-р сард буюу барилгын ажлын сизоны ихэнх хугацааг өнгөрөөж санхүүжигдсэн. Харин үнийн зөрүүний асуудал шийдэгдээгүй.
4. Манай компаниас үнийн зөрүүний асуудлаар удаа дараа зохих шатны байгууллагуудад хандаж байсан бөгөөд 2010 онд 1 сард төслийг хэрэгжүүлэхэд гарсан алдагдал цаашид дуусгахад шаардлагатай байгаа нийт 6 сая долларыг барилгын ажлын төсөв дээр нэмж хөрөнгийг шийдвэрлэж байж уг төсөл дуусах бололцоотой байгаа билээ.

Одоо барилгын ажлын явц эхний хэсэг буюу 3В хэсгийн 14км замын ажил дуусаж улсын ашиглалтанд оруулаад байна. Харин 3С хэсэг буюу 60км замын ажлын үнийн дүнгээр 60%, далан газар шорооны ажил 100%, суурийн ажил 20% асфальтбетон хучилтын ажил 5%, гүүр хиймэл байгууламжийн ажил 70% хийгдээд байна.

Иймээс одоо үнийн зөрүүний асуудлыг захиалагчаас шийдвэрлэж өгвөл манай компаний зүгээс шаардагдах машин механизм, үйлдвэр, хүн, хүч зэрэг ажлын нөхцөл хангагдсан ба замыг дуусган улсын ашиглалтанд оруулахад саатах асуудал байхгүй болно.

Дээрх асуудлуудтай холбоотой баримт бичгийг хавсралтаар хүргүүлэв.


"Насны зам" ХХК-ийн
Булган Уньт. төслийн удирдагч



П.Жавхлантөгс



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2010 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Кувейтын сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Булган-Уньт" чиглэлийн авто зам барих ажлын хэрэгжилтэд хийсэн эрсдэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, ЗТБХБЯ, Автозамын газар, Төслийн удирдах нэгжид хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2010 оны 10 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Эрдэнэт-Булган-Уньтын чиглэлийн автозам барих төслийн Удирдах хорооны дарга, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын дэд сайд Т.Пүрэвдоржид зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

070116001